



## ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 07 сарын 04 өдөр

Дугаар 354

Улаанбаатар хот

### Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны "Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах арга хэмжээний тухай" 148 дугаар тогтоолын 4 дэх заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4.10 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн, нийт 71,025,309.00 (далан нэгэн сая хорин таван мянга гурван зуун ес) төгрөгийн балансын үнэ бүхий барилгын их засварын ажлыг Нийслэлийн ерөнхий боловсролын 63 дугаар сургуулийн холбогдох хөрөнгөд капиталжуулан бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Боловсрол, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Батжаргал, Нийслэлийн хөрөнгө оруулалтын газрын дарга С.Цэрэнсодном, Нийслэлийн ерөнхий боловсролын 63 дугаар сургуулийн захирал С.Эрдэнэбаатар нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө хүлээлцэх ажлыг байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бodoх бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2024 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН  
ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Ц.БАЯР-ЭРДЭНЭ



132001810  
17-r huraldaan.docx